

Батлав: Салбарын дарга:

...../Х.Мягмарсүх /



(Дорноговь аймаг, Мандах сум, Мандах салбар)

**“БЛАСТ”ХХК-ийн “ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭР, ТЭСРЭХ МАТЕРИАЛЫН
АГУУЛАХ ЦОГЦОЛБОР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 2688336

ХЯНАСАН:

Дорноговь аймгийн Байгаль орчны газрын

уул уурхай хариуцсан мэргэжилтэн /Х. Эрдэмтөгс/

Дорноговь аймгийн Мандах сумын Байгаль

орчны асуудал хариуцсан мэргэжилтэн /Э. Сарангоо/

Хэрэгжилтийн гаргасан:

Үйлдвэрийн дарга:/Б.Тогтохбаяр/

Байгаль орчны ажилтан:/Д.Болортуяа/

2025 он

АГУУЛГА


НЭГ. ТЕХНИКИЙН БУС ХУРААНГУЙ.....	2
ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	18
ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН	21
ДӨРӨВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ	36
ТАВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	39
ЗУРГАА. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	39
ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ	41
НАЙМ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ	48
ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	54
АРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ	68
АРВАН НЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ	74
БУСАД. ОРОН НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ	74
ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ	74
ХАВСРАЛТ	78


НЭГ. ТЕХНИКИЙН БУС ХУРААНГУЙ

1.1 Төслийн талаарх мэдээлэл

Хүснэгт 1. Төслийн ерөнхий танилцуулга

Нэг. Ерөнхий мэдээлэл		
1.1	Төсөл хэрэгжүүлэгч:	“Бласт” ХХК “Тэсрэх бодисын хольцын үйлдвэр, агуулахын цогцолбор” төсөл
1.2	Регистрийн дугаар:	РД: 2688336
1.3	Улсын бүртгэлийн дугаар:	УБД: 9011125047
1.4	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Ланд Марк Утас: 325995, 324044
1.5	Газар эзэмших эрхийн гэрчилгээ:	“Бласт” ХХК -д Сумын Засаг даргын 2009 оны 04 сарын 23-ны өдрийн А/191 тоот захирамжаар 60 жил олгосон 20000 мкв газрыг эзэмших эрхийн гэрчилгээ
1.6	Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ	Стандарт хэмжил зүйн газрын 2021 оны 03 сарын 24-ны ӨМД0001298 тоот шийдвэр бүхий “энгийн тэсрэх бодис ANFO, задгай технологийн эмульсийн тэсрэх бодис-blemex bulk, задгай технологийн эмульсийн тэсрэх бодис-blemex blend” төрлийн тохирлын гэрчилгээ
1.7	Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл	Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн яамны 2022 оны 12 сарын 23-ны өдрийн №864 тоот тусгай зөвшөөрөл
1.8	Химийн бодисын тусгай зөвшөөрөл	БОАЖЯ-ны Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалтын албаны 2021 оны 12-р сарын 13-ны өдрийн дугаар 0002031 тоот зөвшөөрөл. 35 төрлийн бодис
1.9	Химийн аюултай бодис, сав баглаа зайлуулах устгах гэрээ	“Түмэн эгшиг” ХХК-ийн 2024 оны гэрээтэй
Хоёр. Төслийн талаарх мэдээлэл		
2.1	Төслийн нэр	“Бласт” ХХК-ийн Дорноговь аймгийн Мандах сумын нутагт хэрэгжүүлэх гэж буй “Тэсрэх бодисын хольцын үйлдвэр, агуулахын цогцолбор” төсөл. Тус цогцолбор нь шинээр байгуулагдаж байгаа бөгөөд 2024 онд БОННУ-ний тайлан батлагдсан.
2.2	Төслийн байршил	Төслийн байршил нь Улаанбаатар хотоос зүүн урагш 500 км, Мандах сумаас урд зүгт 55 км зайд Дорноговь аймгийн Мандах сумын 1-р багийн нутагт байрлана. Газрын байршил нь үйлдвэрлэлийн районд оршдог бөгөөд орон сууц, олон нийтийн байгууламж бүхий хэсгээс 500м-ийн зайд байрладаг нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага” MNS 5105:2001 стандартын шаардлагыг хангаж байна.

		
2.3	Төслийн зорилго	<p>Тус үйлдвэр нь савлагаатай эмульсийн тэсрэх бодисын өндөр хүчин чадал бүхий шинэ шугам нэмж ашиглалтанд оруулан үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, урт хугацаанд хадгалах тээвэрлэхэд тохиромжтой савлагаатай энгийн болон эмульсийн тэсрэх бодисоор хэрэглэгчдэд тасралтгүй тогтмол нийлүүлэх, бүтээн байгуулалтын төслүүдэд хувь нэмэрээ оруулах зорилгоор энэхүү төслийг хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байна.</p>


	 <p>Шингэн хог хаягдал:</p> <p>Нийт 120 ажилтантай гэж үзвэл хоногт 9.6 м3, жилд амралт баяр ёслолын өдрийн хасаад 350 хоног ажиллах хугацаанд нийт хэрэглэх усны хэмжээ 3360 м3/жил болно. Төвлөрсөн цэвэр бохирын системд холбогдоогүй болно. Бага оврын цэвэрлэх байгууламж байгуулна.</p> <p>Хийн хаягдал:</p> <p>Үйлдвэрийн хийн хаягдал үүсэх эх үүсвэрүүд гэвэл автомашины утаа, тээврийн хэрэгслийн тоосжилт зэрэг байна.</p> <p>Үйлдвэрийн ашиглалтын 5 жилийн хугацаанд нийт 1481.7 тн /жилд 493.9 тн/ дизель түлш зарцуулахад хөө – 22.96 тн, СО-0.000148 тн, нүүрстөрөгч–0.000445 тн, NO2–0.00005927 тн, SO2-0.00002963тн, бензопирин-0.000474 тн буюу нийтдээ 22.96 тн хорт хий ялгарахаар байна.</p>
--	--

1.2 Төсөл хэрэгжих орчны байгаль орчны төлөв байдлын хураангуй

1.2.1 Физик газарзүй:

“Тэсрэх бодисын хольцын үйлдвэр, агуулахын цогцолбор” төслийн байршил нь Дорноговь аймгийн Мандах сумын 1-р багийн нутагт байрлах бөгөөд далайн түвшнээс дээш 1316- 1377 метрийн өндөрт байрлана. Төсөл хэрэгжих талбай орчимд газрын гадаргын хэвгийн зонхилох өнцөг 10 байна. Төслийн талбайн далайн түвшнээс дээш 914.1-1034 метрийн үнэмлэхүй өндөрт байрласан тэгш талыг хамарч тогтворжсон байна.

Зураг 1. Төслийн талбайн районы д.т.д үнэмлэхүй өндөршилтийн зураг



1.2.2 Агаарын чанар:

Дэлхий нийтэд агаарын чанарын үзүүлэлт, түүний эрүүл мэнд, экологид үзүүлэх сөрөг нөлөөллийн талаарх нарийвчилсан судалгааны үндсэн дээр ДЭМБ-аас зөвлөмж гаргасан байдаг ба энэ зөвлөмж дээр үндэслэн манай улсад 2007 онд агаарын чанарын стандарт буюу техникийн ерөнхий шаардлага шинэчлэгдэн 2008 оноос мөрдөгдөж эхэлсэн байна. Агаар дахь түгээмэл бохирдуулагчдын агууламжийг агаарын чанарыг үнэлэх гол шалгуур болох агаарын чанарын стандарт /MNS 4585:2016/ дахь бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ, зөвшөөрөгдөх түвшинтэй харьцуулан мөрдөж байна /доорх хүснэгтэнд харуулав/.

Хүснэгт 2. Агаар дахь түгээмэл бохирдуулагчдын хүлцэх агууламж

Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Хүлцэх агууламж, зөвшөөрөгдөх түвшин /жилийн дундаж/
Хүхэрлэг хий (SO ₂)	мкг/м ³	10
Азотын давхар исэл (NO ₂)	мкг/м ³	30
Нүүрсхүчлийн хий буюу угаарын хий (CO)	мкг/м ³	10000
Тоос, тоосонцор,	мкг/м ³	100
Том ширхэглэгт тоосонцор / PM 10/	мкг/м ³	50
Нарийн ширхэглэгт тоосонцор / PM 2.5/	мкг/м ³	25

Судалгааны байршил, хамрагдсан цэгүүд

Хүснэгт 3. Агаарын чанарын хяналт шинжилгээ хийсэн цэгийн байршил

Агаар		Координат	Цэг сонгосон үндэслэл	Дээж авч буй фото зураг
1	1-р цэг	45°58'5.14"N 110°40'44.42"E	Өмнө хийгдсэн хяналт-шинжилгээний үр дүнтэй харьцуулах	
2	2-р цэг	45°50'31.23"N 110°25'1.53"E		
3	3-р цэг	45°42'38.25"N 110°2'41.23"E		
4	4-р цэг	45°44'19.86"N 109°38'31.51"E		
5	5-р цэг	45°47'38.25"N 109°17'59.62"E		

Судалгааны арга, дээж авалт

Төслийн гадна талбай болон барилгын ажлын талбайгаас агаарын хүхэрлэг хий (SO₂), азотын давхар исэл (NO₂), нийт тоос (Нийт жинлэгдэгч бодис) болон дуу шуугиан үзүүлэлт тус бүрийг хээрийн судалгаа болон лабораторийн шинжилгээний үр дүнд тодорхойлов. Үүнд:

Хүхэрлэг хий болон Азотын давхар исэл: Хүхэрлэг хий болон азотын давхар ислийг тодорхойлохдоо химийн шинжилгээний аргачлалаар тодорхойлсон.

Хүхэрлэг хий: Агаараас тетрахлормеркурат натрийн уусмал /ТХМ/-аар норгосон шингээгч гуурсанд 2 л/мин хурдтайгаар 20 минутын турш агаараас сорьц авч шингээгч гуурсны шилэн бөмбөлгийн давхаргад шингэсэн хүхэрлэг хийг лабораторийн нөхцөлд усан уусмалд шилжүүлж тэр уусмал дээрээ формальдегид, парарозанадины уусмал нэмэхэд үүссэн нэгдлийн өнгөний эрчимшлийг спектрофотометрээр хэмжин хүхэрлэг хийн агууламжийг тодорхойлов.

Азотын давхар исэл: Агаараас азотын давхар ислийг үл хатах мышьяклаг хүчлийн натрийн давс агуулсан кали иодын уусмалаар норгосон шингээгч гуурсаар 0.25 л/мин-ын хурдтайгаар 20 минутын турш соруулан сорьц авч шингээгч гуурсны шилэн бөмбөлгийн давхаргаанд шингээж лабораторийн нөхцөлд уусмалд шилжүүлж үүссэн нитрит ион сульфанадины хүчилтэй харилцан үйлчилж diazonегдлийг үүсгэх бөгөөд тэр нь -нафтиламинтай урвалд орж азобудагч бодисыг уусмалын өнгөний эрчимшлээр азотын давхар ислийн хэмжээг тодорхойлов.

Нийт тоос (Нийт жинлэгдэгч бодис): Төслийн талбай орчмын агаарт агуулагдах нийт тоос (Нийт жинлэгдэгч бодис)-ны агууламжийг DustTrak 8530 зөөврийн багажийн тусламжтай тодорхойлсон.

Дуу чимээ: Шуугианы хэмжилтийг MNS 5003:2000 “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугиан хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага.” стандарт аргачлалын дагуу EXTECH Noise Dosimeter, Datalogger, and Sound Level Meter SL355) загварын зөөврийн багажаар тодорхойлсон.

Судалгаанд ашигласан багаж хэрэгсэл



Хяналт шинжилгээний үр дүн

Агаарын чанарын хяналтын 2 цэгээс авсан нийт тоосны хэмжээг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас даваагүй, хэвийн хэмжээнд байна.

Хүснэгт 4. Нийт тоос / Нийт жинлэгдэгч бодис / хэмжилтийн үр дүн

№	Сорьц авсан цэг	Нийт тоос /Нийт жинлэгдэгч бодис/
---	-----------------	-----------------------------------

1	Гадна ажлын талбай	0.87
2	Ажлын талбай	0.79
3	Тээврийн зам	0.92
Агаарын чанарын стандарт MNS 4585: 2016		0.500

Агаарын бохирдуулагч бодисын хэмжилт

Агаарын чанарын хяналтын 2 цэгээс авсан хүхэрлэг хий болон азотын давхар ислийн хэмжээг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас давсан үзүүлэлт илрээгүй хэвийн хэмжээнд байна.

Хүснэгт 5. Агаарын бохирдуулагч бодисын хэмжилтийн үр дүн

№	Сорьц авсан цэг	NO2 (Азотын давхар исэл мг/м3)	SO2 (Хүхэрлэг хий мг/м3)
1	Гадна ажлын талбай	0.066	0.065
2	Ажлын талбай	0.085	0.115
3	Тээврийн зам	0.085	0.115
Агаарын чанарын стандарт MNS 4585: 2016		0.200	0.450

Дуу шуугианы хэмжилт

Дуу шуугианы үзүүлэлтийг хяналтын 2 цэгийн ойр орчимд хэмжсэн ба 16 цагийн дундаж үр дүнг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даваагүй байна.

Хүснэгт 6. Дуу шуугианы хэмжилтийн үр дүн

№	Сорьц авсан цэг	Дуу чимээ дБ (А)
1	Гадна ажлын талбай	65
2	Ажлын талбай	60
3	Тээврийн зам	55
Агаарын чанарын стандарт MNS 4585: 2016 дБ (А), 16 цагийн дундаж		60

Дүгнэлт, зөвлөмж

Төслийн эзэмшил талбайн агаарын хүхэрлэг хий (SO₂), азотын давхар исэл (NO₂), нийт тоос (Нийт жинлэгдэгч бодис) хийж гарсан үр дүн тус бүрийг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага байна.


Төслийн эзэмшил гадна ажлын гадна ажлын талбай дуу шуугиан хэмжилт хийж гарсан үр дүн тус бүрийг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс их байна.

Агаарын чанарын индекс	Агаарын чанарын ангилал	Тэмдэглэгээ (өнгөөр)	Эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл
0-50	Цэвэр	Ногоон	Хүний эрүүл мэндэд сөрөл нөлөө үзүүлэхгүй.
51-100	Хэвийн	Шар	Агаарын чанар шаардлага хангах боловч, зарим бохирдуулах бодисын нөлөөлөлд хэт мэдрэг хүмүүс өртөж болно. Тухайлбал: озон, нарийн ширхэглэгт тоосонцрын нөлөөллийн улмаас хэт мэдрэг хүмүүст амьсгалын замын өвчний шинж тэмдэг илрэх магадлалтай.
101-250	Бага зэргийн бохирдолтой	Улбар шар	Хэт мэдрэг хүмүүсийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл илэрнэ. Зүрх судас, амьсгалын замын архаг өвчтэй, ялангуяа гуурсан хоолойн багтраа өвчтэй хүмүүс нөлөөлөлд илүү өртөнө.
251-400	Дунд зэргийн бохирдолтой	Ягаан	Нийт хүн амын эрүүл мэндэд бага зэргийн сөрөг нөлөөлөл илэрч эхэлнэ. Хэт мэдрэг хүмүүсийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл хүндээр илэрнэ.
401-500	Их бохирдолтой	Хүрэн	Удаан хугацаагаар гадаа байхад нийт хүн амын эрүүл мэндэд мэдэгдэхүйц сөрөг нөлөөлөл илэрнэ.
500<	Маш их бохирдолтой	Улаан	Удаан хугацаагаар гадаа байхад нийт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл илэрнэ.

1.2.3 Хөрс орчин:

Төсөл хэрэгжих талбай нь Дорноговь аймгийн Мандах сумын 1-р багийн нутаг дэвсгэрт хамаарна. Тус нэгж талбарт тал газар, хөндий хотгорын хөрс тархсан байна.

Зураг 3. Төслийн талбайн хөрсөн бүрхэвчийн хэв шинж



Хүснэгт 7. Мандах сумын төслийн талбайн дээж авсан цэгийн химийн үзүүлэлт

№	Гүн, см	pH H ₂ O	ЦДЧ, dS/m	Давс	Ялзмаг %	CaCO ₃	NO ₃	Солилцох суурь, мг- экв/100 гр			Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
								Ca+Mg	Ca+2	Mg+2	P ₂ O ₅ ,	K ₂ O
Дээж 1 - Мандах сум												
1	0-20	7.85	0.039	0.016	0.83	0.0	0.12	18	10	8	2.2	39

Дээж-1.Химийн шинжилгээний үр дүнгээр хөрс нь сул шүлтлэг урвалын орчинтой, ялмагийн агууламж маш бага, хялбар уусах давсны агууламж маш их буюу давсжилттай, солилцох сууриас Са дунд, Mg маш их агууламжтай мөн хөдөлгөөнт фосфорын хангамж маш бага, калийн агууламж бага байна. Хөрсний үржил шимийн түвшин муу байна.

Хүснэгт 8. Мандах сумын төслийн талбайн дээж авсан цэгийн химийн үзүүлэлт

№	Гүн, см	pH H ₂ O	ЦДЧ, dS/m	Давс	Ялзмаг %	CaCO ₃	NO ₃	Солилцох суурь, мг- экв/100 гр			Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
								Ca+Mg	Ca+2	Mg+2	P ₂ O ₅ ,	K ₂ O
Дээж 4 - Мандах сум												
1	0-20	8.04	0.044	0.018	1.19	0.0	0.13	30	19	11	3.6	35

Дээж-4.Химийн шинжилгээний үр дүнгээр хөрс нь сул шүлтлэг урвалын орчинтой, ялмагийн агууламж маш бага, хялбар уусах давсны агууламж маш их буюу давсжилттай, солилцох сууриас Са их, Mg маш их агууламжтай мөн хөдөлгөөнт фосфорын хангамж маш бага, калийн агууламж бага байна. Хөрсний үржил шимийн түвшин муу байна.

Хүснэгт 9. Мандах сумын төслийн талбайн дээж авсан цэгийн химийн үзүүлэлт

№	Гүн, см	pH H ₂ O	ЦДЧ, dS/m	Давс	Ялзмаг %	CaCO ₃	NO ₃	Солилцох суурь, мг- экв/100 гр			Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
								Ca+Mg	Ca+2	Mg+2	P ₂ O ₅ ,	K ₂ O
Дээж 7 – Мандах сум												
1	0-20	8.20	0.055	0.022	0.60	0.0	0.09	15	11	4	3.7	37

Дээж-7.Химийн шинжилгээний үр дүнгээр хөрс нь дунд шүлтлэг урвалын орчинтой, ялмагийн агууламж маш бага, хялбар уусах давсны агууламж маш их буюу давсжилттай, солилцох сууриас Са хангалттай, Mg маш их агууламжтай мөн хөдөлгөөнт фосфорын хангамж маш бага, калийн агууламж бага байна. Хөрсний үржил шимийн түвшин муу байна.

Хөрсний механик бүрэлдэхүүн

Хөрсний хатуу хэсгийг бүрдүүлж байгаа жижиг ширхгүүдийн хэмжээгээр нь ангилан тэдгээрийг хувиар илэрхийлснийг механик бүрэлдэхүүн гэнэ. Энгийн ширхгийн хэмжээгээр нь шороо ба чулуу гэсэн хоёр том бүлэгт хуваана. Хөрсний задлан шинжилгээнд бэлтгэхэд 1 мм-ийн шигшүүрээр шигших бөгөөд түүнээс том хэмжээтэйг чулуу, харин шигшигдэж орсон 1 мм-ээс бага ширхэгтэйг шороо гэнэ (Аваадорж бусад 2012).

Хүснэгт 10. Хөрсний механик бүрэлдэхүүн Мандах сумын хөрсний дээж

Дээжний нэр	Дээж авсан гүн, см	Жижиг хэсгийн эзлэх хэмжээ мм, хувиар						
		Элс		Тоос				Шавар
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Дээж 1 –Мандах сум								
1	0-20	36.3	43.4	11.3	2.1	2.8	4.1	9.0

Дээж-1. Хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлох Н.А. Качинскийн ангиллын аргаар физик шаврын эзлэх хувиар тодорхойлоход элсэрхэг механик бүрэлдэхүүнтэй байна.

Хүснэгт 11. Хөрсний механик бүрэлдэхүүн Мандах сумын хөрсний дээж

Дээжний нэр	Дээж авсан гүн, см	Жижиг хэсгийн эзлэх хэмжээ мм, хувиар						
		Элс		Тоос				Шавар
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Дээж 4 – Мандах сум								
1	0-20	26.4	58.3	4.9	3.5	4.5	2.4	10.4

Дээж-4. Хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлох Н.А. Качинскийн ангиллын аргаар физик шаврын эзлэх хувиар тодорхойлоход элсэрхэг механик бүрэлдэхүүнтэй байна.

Хүснэгт 12. Хөрсний механик бүрэлдэхүүн Мандах сумын хөрсний дээж

Дээжний нэр	Дээж авсан гүн, см	Жижиг хэсгийн эзлэх хэмжээ мм, хувиар						
		Элс		Тоос				Шавар
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Дээж 7 – Мандах сум								

1	0-20	32.7	35.9	18.4	6.1	2.2	4.8	13.0
---	------	------	------	------	-----	-----	-----	------

Дээж-7. Хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлох Н.А. Качинскийн ангиллын аргаар физик шаврын эзлэх хувиар тодорхойлоход элсэрхэг механик бүрэлдэхүүнтэй байна.

Хүснэгт 13. Хөрсний механик бүрэлдэхүүний шинж чанар

Хөрсний шинж чанарын үзүүлэлт		Механик бүрэлдэхүүн		
		Элсэнцэр ба хөнгөн шавранцар	Дунд шавранцар	Хүнд шавранцар, шавар
1	Боловсруулалт	-	+	++
2	Тэжээлийн бодис агуулалт	-	+	++
3	Ургамлын тэжээлийн бодис нийлүүлэлт	-	++	+
4	Хоруу бодисын хуримтлал	-	++	++
5	Ус агуулалт	0	++	++
6	Ургамал ус нийлүүлэлт	-	+	-
7	Механик шүүлт	-	+	-
8	Физик-химийн шүүлт	-	++	+
9	Ус шүүлт	++	0	-
*++ маш сайн (дээд зэрэг), + сайн (өндөр), 0 хангалттай (дунд зэрэг), - тааруу, -- нэн хангалтгүй				

Дээрх хүснэгтээс үзэхэд элсэрхэг хөрс нь тэжээлийн бодис, ус агуулалт болон физик химийн шүүлт нэн хангалтгүй, ургамлын тэжээлийн бодис нийлүүлэлт, хоруу бодисын хуримтлал, ургамлын ус нийлүүлэлтээр тааруу харин механик шүүлт сайн, хөрсний боловсруулалт, ус шүүлтээр маш муу гэсэн үзүүлэлттэй байна.

Хүнд металлын агууламж

Хүснэгт 14. Хөрсний хүнд металлын шинжилгээ Мандах сум

Дээж авсан газар, Газар зүйн байршил	Дээж авсан гүн, см	Хүнд металлын агууламж мг/кг					
		Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Zn /Цайр/	Cr /Хром/	Cu /Зэс/
Дээж 1	0-20	7.0	0.0	58.4	48.6	28.6	19.1
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019							
Элсэрхэг хөрс		60	1	50	100	60	60

Шавранцар хөрс		100	1.5	70	150	100	80
Шаварлаг хөрс		150	3	100	300	150	100

Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламжийг лабораторийн шинжилгээгээр тодорхойлж үзэхэд стандартын хүлцэх агууламж болон хортой, аюултай агууламжаас хартугалга давсан үзүүлэлттэй байна. Бусад нь стандартаас бага байна.

Хүснэгт 15. Хөрсний хүнд металлын шинжилгээ Мандах сум

Дээж авсан газар, Газар зүйн байршил	Дээж авсан гүн, см	Хүнд металлын агууламж мг/кг					
		Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Zn /Цайр/	Cr /Хром/	Cu /Зэс/
Дээж 4	0-20	5.8	0.0	54.2	33.9	42.9	19.6
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019							
Элсэрхэг хөрс		60	1	50	100	60	60
Шавранцар хөрс		100	1.5	70	150	100	80
Шаварлаг хөрс		150	3	100	300	150	100

Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламжийг лабораторийн шинжилгээгээр тодорхойлж үзэхэд стандартын хүлцэх агууламж болон хортой, аюултай агууламжаас хартугалга давсан үзүүлэлттэй байна. Бусад нь стандартаас бага байна.

Хүснэгт 16. Хөрсний хүнд металлын шинжилгээ Мандах сум

Дээж авсан газар, Газар зүйн байршил	Дээж авсан гүн, см	Хүнд металлын агууламж мг/кг					
		Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Zn /Цайр/	Cr /Хром/	Cu /Зэс/
Дээж 7	0-20	7.0	0.0	62.2	66.6	28.9	24.0
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019							
Элсэрхэг хөрс		60	1	50	100	60	60
Шавранцар хөрс		100	1.5	70	150	100	80
Шаварлаг хөрс		150	3	100	300	150	100

Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламжийг лабораторийн шинжилгээгээр тодорхойлж үзэхэд стандартын хүлцэх агууламж болон хортой, аюултай агууламжаас хартугалга давсан үзүүлэлттэй байна. Бусад нь стандартаас бага байна.

1.2.5 Төсөл хэрэгжих орчны нийгэм-эдийн засгийн хураангуй

Дэд бүтэц

Зам тээвэр: Сумын газар нутгаар Дорноговь таван толгойн шороон зам, багууд шороон замаар холбогдсон.

Цахилгаан хангамж: Сум нь Оюутолгойгоос Цагаан суваргын зэсийн орд чиглэлийн 160 км урт, 220 кВ-ын ЦДАШ ашиглалтад орж, Цагаан суваргаас Мандах сум руу чиглэсэн 22 кВ-ын агаарын шугамаас эрчим хүч хангагдсан.

Ус хангамж: Сумын төвд цэвэр усны эх үүсвэрийн 1 гүний худаг, 45м³/хоног хүчин чадалтай 1 насос станц, 50м³/хоног хүчин чадалтай 1 ус зөөлрүүлэх тоног төхөөрөмжтэй. Сумын төвийн ус зөөврийн машинаар айл өрх болон албан газрын усыг зөөж түгээдэг.

Дулаан хангамж: Сумын айл өрх болон албан газар нь уурын зуух болон энгийн галалгаагаар дулааны асуудлыг шийдвэрлэдэг. Сумын төвд сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв, нийтийн ахуй үйлчилгээ, тамгын газарт нийт 8 бага оврын уурын зуух ажилладаг.

Орон сууцны хангамж: Сумын хэмжээнд 24-н айлын орон сууц, сургуулийн багш нарын орон сууц, эрүүл мэндийн төвийн албан хаагчдын орон сууц зэрэг 34-н энгийн галалгаагаар орон сууцанд иргэд амьдардаг. Суманд инженерийн бүрэн хангамжтай орон сууц баригдаагүй.

Эдийн засаг

Тус суманд “Монголын алт” ХХК, “Их говь энержи” ХХК, “ЭЙ ВЭЙ ЭКС” ХХК, “Голдон гровуз” ХХК, “KINCORA COPPER” ХХК зэрэг байгууллага уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаагаас гадна өөрийн сумын “Богд мандах” хоршоо, “Говь трайн” ХХК, “Мандах өлзийт” ХХК, “Монгол тарвас” ХХК, “Шувуун хад” ХХК, “Богд хайрхан трейд” ХХК зэрэг аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.

Тус сум нь жилд дундажаар орон нутгийн төсвийн орлогод 100,1 сая төгрөгний татвар төвлөрүүлдэг. Татварын нийт орлогын 4,5%-ийг аж ахуй эрхэлсэний орлого, 7,0%-ийг орлого тодорхойлох боломжгүй иргэдийн татвар, 4,3% суутгагчийн хувь хүнд олгосоны татвар, 2,5 %-ийг улсын тэмдэгтийн хураамж, 13.9%-ийг түгээмэл тархацтай ашигт малтмал, ус рашаан ашигласан татвар, лизенцийн төлбөр 67,8%-ийг тус тус эзэлдэг.

Хүн ам зүй

Хүснэгт 17. Хүн ам, өрхийн тоо, 2020 он

Үзүүлэлт	Сумын төвд	Хөдөөд	Нийт
Хүн амын тоо	410	1156	1566
Өрхийн тоо	140	334	474
Суурин хүн ам	1566		

Хүснэгт 7. Хүн ам зүйн судалгаа

Үзүүлэлт	Эр	Эм	Нийт
----------	----	----	------

0-16 насны хүүхдийн тоо	243	249	492
Хөдөлмөрийн насны хүний тоо	484	460	944
Ажил эрхэлдэг хүний тоо	332 376 708		
Оюутан суралцагч	44 40 84		
Ажил эрхэлдэггүй	79 33 112		
Ахмадын тоо	93	37	130
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо	29 11 40		

Дорноговь аймгийн статистик


Дорноговь аймгийн хүн амын тоо 1979-1989 онд бүх сумдын хүн ам жигд өссөн, 1989-2000 оны хооронд Иххэт, Мандах, Сайхандулаан, Сайншанд сумдаас бусад 10 сумын хүн амын тоо, 2000-2010 онд Айраг, Даланжаргалан, Сайншанд, Замын-Үүд сумын хүн амын тоо өссөн байна. 2010-2019 онд Айраг, Иххэт, Хатанбулаг сумын хүн амын тоо 0.03-0.62 хувиар буурч, бусад сумдын хүн амын тоо жилд дунджаар 0.11-4.20 хувиар өслөө.

Зураг 4. Хүн амын жилийн дундаж өсөлт, сумаар, 2013-2019 онд



Дорноговь аймгийн хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь 1969-1979 онд 3.25 хувиар өсч байсан нь хамгийн их өсөлттэй үе байсан бол 1989-2000 онд хүн амын тоо жилд дунджаар 1.10 хувиар буурч байв. 2010-2019 онд энэ үзүүлэлт 2.58 хувь болж өссөн байна.

Зураг 5. Хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь, 2010-2019 онд



ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх эрх зүйн баримт бичиг юм.

“Бласт” ХХК-ийн Дорноговь аймгийн Мандах сумын 1-р багийн нутагт хэрэгжүүлж буй “Тэсрэх бодисын хольцын үйлдвэр, агуулахын цогцолбор” төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А618 тоот тушаал, “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, 2012 оны 5 сарын 17-ны өдрийн “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалын “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”, ЗАСГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ 02 САРЫН 08-НЫ ӨДРИЙН 58 ДУГААР ТОГТООЛЫН 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ын 2-р хэсэгт тусгасны дагуу, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд тулгуурлан боловсруулав.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Бласт” ХХК -ийн заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

Төслийн төлөвлөлтөд өөрчлөлт оруулах бүрд төлөвлөгөөнд нэмэлт тодотгол хийлгэж байх шаардлагатай.

Хүснэгт 21. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Тусгасан төсөв	Зарцуулсан төсөв	Баримтлах хууль, журам, стандарт
1.2.1	1.2) Усан орчин бохирдох, Зөвшөөрөлгүй	Ус ашиглалттай холбоотой дүгнэлт, гэрээ, зөвшөөрөл авч ажиллах	Үйл ажиллагааны зардал	50,000	2025 оны Ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулах хүсэлтийг 2025.09.19-ний өдөр 02/1004 тоот албан бичгээр хүргүүлэн 2025 оны 10 сарын 01 өдөр шийдвэрлэсэн.
1.2.2	ус ашиглах, усны нөөц ашигласны төлбөр	Холбогдох байгууллагаас хаягдал усны дүгнэлт, зөвшөөрөл авч ажиллах	Үйл ажиллагааны зардал	0	Хаягдал усны дүгнэлтийг 2025 оны 09 сарын 25нд холбогдох байгууллагаар гаргуулсан.
1.2.3	төлөгдөхгүй байх	Усыг зохистой ашиглах, гүний усны талаар ажилчдад мэдээлэл өгөх	Үйл ажиллагааны зардал	0	Сургалтад нийт 17 ажилтан хамрагдаж, оролцсон ажилчид гарын үсгээрээ баталгаажуулсан. Сургалт нь зурагт самбар ашиглан танхимын хэлбэрээр явагдсан бөгөөд ажилчид идэвхтэй сонсож, усны хэрэглээг зөв зохистой болгох арга замуудын талаар ойлголттой болсон.
1.3.1	1.3) Хөрсний бохирдол, техник нөлөөгөөр хөрс болон ургамалд сөргөөр нөлөөлөх	Шатах тослох материал асгаралтаас хөрсөнд бохирдол үүсч болзошгүй Шатах тослох материал алдагдсанаас хөрс бохирдуулж болзошгүй, түүнээс урьдчилан сэргийлэх талаар ажилчдад зөвлөмж, мэдээлэл өгөх	Үйл ажиллагааны зардал	0	Сэдэв: Шатах тослох материал алдагдсанаас хөрс бохирдуулж болзошгүй нөхцөлөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж, мэдээлэл өгөх Хугацаа: 2025 оны 09 сарын 20-ны өдөр Оролцогчдын тоо: 20 хүн
1.3.2	сөргөөр нөлөөлөх	Хөрсөнд бохир нэвчдэггүй био жорлон суурилуулах	Үйл ажиллагааны зардал	18,735,000	Компанийн байгаль орчныг хамгаалах бодлогын хүрээнд ажилчдын хэрэгцээнд зориулан хөрсөд бохир нэвчдэггүй, стандартын шаардлага хангасан био жорлонг суурилууллаа. Энэхүү ариун цэврийн байгууламж нь орчин үеийн шийдэлтэй,

					олон хүний зэрэг ашиглах боломжтой, эрэгтэй болон эмэгтэй хэсгээр тусгаарлагдсан кабинудаас бүрдсэн. Ажил гүйцэтгэлийн зардал нь 18,735,000 төгрөгөөр тооцогдож, баталгаат хугацаатайгаар хүлээлгэн өгөгдсөн.
1.3.3		Тээврийн хэрэгслийг маршрутын бус замаар явахыг хориглосон таних тэмдэг бүхий самбар байрлуулах	500,000	720,000	Тэмдэг, самбаруудыг стандартын дагуу байрлуулж дуусгасан бөгөөд нийт 720,000 төгрөгийн зардал гарсан байна. Энэ ажил нь маршрутын хяналт, байгаль орчныг хамгаалах зорилгод үр дүнтэй хэрэгжсэн гэж үзэж байна.
№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ			Баримтлах хууль, журам, стандарт
1.4	1.4) Ургамал	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс олон сам үүсэх, урамлан нөмрөгт сөрөг нөлөө үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилгоор үйлдвэр, агуулахаас амрах байр хооронд зорчих замыг хусч сайжруулах	Үйл ажиллагааны зардал	0	Үйлдвэр, агуулах болон амрах байр хоорондын хөдөлгөөний гол чиглэлд ашиглагддаг замын хэсгийг хусч, тэгшлэх замаар сайжруулалт хийсэн. Энэхүү ажлын хүрээнд: Тээврийн хэрэгсэл явах хэсгийн замыг тэгшлэн хусч, хөдлөх тоосонцор үүсэх эрсдэлийг бууруулав. Олон сам, гүвээ, хонхорыг арилгаж, хөрс эвдрэлд орох нөхцлийг саармагжуулав; Урамлан нөмрөгт үзүүлэх механик даралт, хөрс бутралтыг хязгаарлан, ургамлын бүрхэвчид учрах сөрөг нөлөөг бууруулав.
11	Амьтан	Орон нутгийн байгууллагатай хамтран Биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэх	580,000	700,000	Амьтны тухай хууль Ажлын хүрээнд орон нутгийн санал хүсэлтэд үндэслэн ан амьтдад зориулсан хорголтны тэжээл бэлтгэн нийлүүлсэн. Нийт 15 ширхэг хорголтны тэжээл (нийт өртөг 580,000 төгрөг) бэлтгэж, холбогдох сумын Байгаль орчны асуудал хариуцсан албан тушаалтанд хүлээлгэн өгсөн болно.
			1,080,000	25,256,342	

ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

3.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээний хэрэгжилт

3.1.1 Агаарын чанар - Агаар дахь тоосжилтыг хэмжих, шинжилгээ хийлгэх

Ажлын зорилго:

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль орчны стандартыг хангах зорилгоор үйлдвэрлэл, агуулах орчим болон хүн амьдрах бүсийн агаарт тоосжилтын хэмжээг тогтоож, шинжилгээ хийлгэсэн.

Ажлын гүйцэтгэл:

2025 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу агаарт тархаж буй нийт тоосонцор (TSP, PM10, PM2.5)-ын агууламжийг тодорхойлох шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэлээ.

Шинжилгээг үйлдвэрлэлийн бүс, агуулах орчин, хүн амьдардаг цэгүүдэд нийт **1 удаа** гүйцэтгэсэн.

Шинжилгээний үр дүн:

Хэмжилтийн дүнгүүдийг холбогдох стандартуудтай (MNS 4585:2007, MNS 3384:1982, MNS 4048:1988) харьцуулан үнэлэхэд агаар дахь тоосжилтын хэмжээ зөвшөөрөгдөх хязгаарт багтаж байсан.

Дүгнэлт:

Агаар дахь тоосжилтын түвшин хэвийн, байгаль орчны стандартад нийцсэн байна.

Цаашид энэ ажлыг улирал бүр тогтмол хийж, үр дүнг хяналт шинжилгээний тайланд тусгаж ажиллана.

Шаардлагатай зардал: 278.0 мянган төгрөг.

Төрөл	Нэгж үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
Агаар	24500	4	98000
Тоос	20000	4	80000
Томилолт	50,000		50000
Түлш			50,000
Нийт зарцуулсан төсөв			278,000

Гүйцэтгэсэн байгууллага:

Дорноговь аймгийн ус цаг уур,
орчны шинжилгээний газар



3.1.2 Агаарын чанар - Тээврийн хэрэгслийг үзлэг оношилгоонд тогтмол хамруулах
Мандах салбарын автотээврийн хэрэгслүүдийг 2025 онд тогтмол үзлэг оношилгоонд хамруулж, техникийн бүрэн бүтэн байдлыг ханган ажиллав. Үүнд Prado-150, Майтүн/Hyundai HD65, Норд бенцийн гурван нэгж, Погрузчик/Zoomlion FD30 зэрэг нийт 6 тээврийн хэрэгсэл хамрагдсан байна.

Тухайлбал, 34-48 УБС улсын дугаартай Toyota Land Cruiser Prado (2019 онд үйлдвэрлэсэн) автомашин 2025 оны 06 дугаар сарын 12-нд үзлэгт орж, 2026 оны 06 дугаар сарын 05-ныг хүртэл хүчинтэй үнэлгээ авч тэнцсэн. Мөн уг тээврийн хэрэгслийн татвар, хураамжийн төлбөр болох АТБӨЯХ татвар – 241,542₮, АБ төлбөр – 4,200₮, АЗА төлбөр – 150,000₮-ийг бүрэн төлсөн бөгөөд нийт 395,742₮ төлбөрийг барагдуулсан байна.

Ийнхүү салбарын бүх автомашинууд техникийн хяналтын үзлэгт хамрагдаж, шаардлагатай татвар болох **1,862,742** төгрөг бүхий хураамжийг бүрэн төлсөн нь автотээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагаа, стандартын шаардлагыг ханган ажиллах нөхцөлийг бүрдүүлэв.

Мандах салбарын автын үзлэгт орох машин техникүүд					
№	Машины марк	Улсын дугаар	Татвар	Үйлдвэрлэсэн огноо	Арлын дугаар
1	Prado-150	34-48 УБС	395,742.00	2019	JTEBH3FJ70K215216
2	Майти / hyundai HD65 /	73-47 УНХ	455,000.00	2011	KMFGA17LPCC182926
3	Норд бенз	07-15 УНМ	267,000.00	2010	LBZF56JB4AA062653
4	Норд бенз	80-77 УНЗ	267,000.00	2010	LB2F56JB1AA008548
5	Норд бенз	54-36 УНД	267,000.00	2018	LBZF46FAXJA005487
6	Погрузчик / Zoomlion FD30 /	08-36 УН	211,000.00	2018	185111936J3D11002
			1,862,742.00		

Тээврийн хэрэгсэл

Улсын дугаар **3448УБС**

Загвар **Toyota Land Cruiser Prado**

Үйлдвэрлэсэн он **2019**

Техникийн хяналтын үзлэгийн мэдээлэл

🕒 Үзлэгт орсон огноо **2025/06/12**

🕒 Үзлэгт дахин орох огноо **2026/06/05**

📄 Тэнцсэн эсэх ✔ Тэнцсэн

Тээврийн хэрэгсэл

Улсын дугаар **3448УБС**

Загвар **Toyota Land Cruiser Prado**

Үйлдвэрлэсэн он **2019**

Татвар, хураамж

Төлөөгүй Төлсөн

Он	Дэлгэрэнгүй			Нийт дүн	Төлөв
2025	АТБӨЯХТатвар: 241,542 ₮	АБТөлбөр: 4,200 ₮	АЗАТөлбөр: 150,000 ₮	395,742 ₮	✔ Төлөгдсөн

Үндсэн нэс

3.1.3 Агаарын чанар - Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилтыг бууруулахад хурдны хязгаарыг дагаж мөрдүүлэх, тэмдэг тэмдэглэгээ байршуулах.


Мандах салбарын тэсрэх бодисын хольцын үйлдвэр, агуулахын цогцолбороос ажилчдын амрах байр болон Цагаан суваргын замтай холбосон сайжруулсан шороон замын ажлыг “Хай Мэнг Тонгда зам харилцаа бүтээн байгуулалт” ХХК-ийн боловсруулсан зураг төсөл, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлээ.

Замын далан байгуулах зорилгоор 2025 оны 3 дугаар сарын 25-наас 30-ны хооронд “Хос хүчит хүлэг” ХХК нийт 621 цооног өрөмдөж, 4 дүгээр сарын 6-нд гурван хэсэг газарт тэсэлгээний ажлыг гүйцэтгэсэн бөгөөд тэсэлгээ хэвийн, жигд бутлагдалтай болж дууссан. Үүний дараа 4 дүгээр сарын 8-нд замын компани нүүж ирж байрлан, 4 дүгээр сарын 9-нөөс эхлэн зүүн талын тэсэлсэн овоолгоос баруун чиглэл рүү буюу Цагаан суваргын уурхайн замаас үйлдвэрийн чиглэл хүртэл сайжруулсан шороон замын далангийн ажлыг эхлүүлэв.

Ажлын явцад 4 дүгээр сарын 30-нд түр хугацаанд зогсоож нүүсэн ч, 6 дугаар сарын 18-нд эргэн ирж замын ажлаа үргэлжлүүлэн хийж, 6 дугаар сарын 30-нд бүрэн дуусгаж, хүлээлгэн өгсөн байна. Замын ажлыг нийтдээ 33 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэсэн бөгөөд зам дагуу шаардлагатай хурдны хязгаар болон аюулгүй байдлын тэмдэг, тэмдэглэгээг бүрэн байршуулсан. Замын тэмдэг тэмдэглэгээ байршуулах ажилд нийт **2,910,600** зарцуулсан.



Сайжруулсан шороон замын батлагдсан план зураг



3.2 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээний хэрэгжилт

3.2.1 Ус ашиглалттай холбоотой дүгнэлт, гэрээ, зөвшөөрөл авч ажиллах

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2024.06.14-ны 276 тоот албан бичгийн дагуу 3 цооног өрөмдөж, худаг гаргах зөвшөөрлийг авч Од шандас ХХК-иар усны мэргэжлийн байгууллагаар цооногоо өрөмдүүлэн худгийн паспортыг баталгаажуулсан. 2025 оны Ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулах хүсэлтийг 2025.09.19-ний өдөр 02/1004 тоот албан бичгээр хүргүүлэн 2025 оны 10 сарын 01 өдөр шийдвэрлэсэн.

Бичиг баримтын нэр	Хугацаа	Тайлбар
Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт	2024 оны 7 сарын 1 өдөр	Дугаар Е-2406-000205
Цооног өрөмдөлгийн зөвшөөрөл	2024 оны 6 сарын 14 өдөр	276
Ус ашиглах гэрээ	2024 оны 06 сарын 20 өдөр	“Түмэн-Айл Инвест” ХХК гэрээ
Ус ашиглах дүгнэлт	2025 оны 10 сарын 01 өдөр	ДАБОГ дугаа/ 63
Ус ашиглах гэрээ		

“Бласт” ХХК-ийн Мандах салбарын 2025 оны байгаль орчны Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан

БАТЛАВ “ТҮМЭН АЙЛ ИНВЕСТ” ХХК
ДОРНОГОВЬ САЛБАРЫН ЗАХИРАЛ
НОРГИЙН
ХАМГААГАХ
УЛАМ

БАТЛАВ “БЛАСТ”
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
А.ТЭМҮҮЛИН

ГҮНИЙ ХУДАГ АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ

2024.06.20 №С-71/24 Дорноговь аймаг, Мандах сум

Нэг талаас Дорноговь аймаг, Сайншанд сум, 2 дугаар баг, эрх чөлөөний гудамж, 2-230 тоот хаягтай, “Түмэн Айл Инвест” ХХК-ийн Дорноговь салбар (шашид “Ус ашиглуулагч” гэх) түүнийг төлөөлж Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал Б.Манасүрэн

Нөгөө талаас, Хан-Уул дүүрэг, 1 дүгээр хороо, 203 тоот хаягтай “Бласт” ХХК /шашид Ус ашиглуулагч/ түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал А.Тэмүүлэн нар харилцан тохиролцож энэ гэрээг байгуулав.

Талууд гэрээ байгуулахдаа Усны тухай хууль, Иргэний хуулийг тус тус удирдлага болгов.

НЭГ. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1.1. Ус ашиглуулагч нь өөрийн уурхайг байрлах, өөрийн эзэмшлийн 2 гүний худгийг Ус ашиглагчтай байгуулсан гэрээний дагуу унд ахуй болон барилга угсралтын үед шаардагдах хэрэгцээнд ашиглана.

1.2. Ус ашиглагч нь ус ашиглахны төлбөрийг төснө.

ХОЁР. ГҮНИЙ ХУДИЙН МЭДЭЭЛЭЛТ

2.1. Ус ашиглах зориулалт: Унд ахуй болон технологи үед шаардагдах хэрэгцээнд ашиглана.

- 2.2. Байршил: Дорноговь аймаг, Мандах сум, Алхан Тээг баг
- 2.3. Селбицол: Үйлдвэрийн гүний худаг 108°17'06.05" 44°08'41.73", Ажилчдын гүний худаг 108°24'42.63 44°03'12.7
- 2.4. Хүчин чадал: 2 гүний худагтай, ТАНГ-1 худаг 110 м гүнтэй 2 л/с, Худал-2 100 м гүнтэй 0,5 л/с

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 3.1. Энэхүү гэрээ нь 2024.06.20-2029.06.20-ны өдрийг хүртэл 5 жилийн хугацаанд үйлчилнэ.
- 3.2. Гэрээг хугацаанаас нь өмнө харилцан тохиролцож дуусгаар болгож болно.

4.6 Гэрээнд заасны дагуу сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/12 дугаар тогтоолоор баталсан хог хаягдал гаргасны сарын төлбөрийг 150,000 /нэг зуун тавин мянган төгрөг/-өөр тооцож До.Ма Хог хаягдлын хураамж /Төрийн сан банк 100060600947 данс/-нд бүрэн төлөх

Ажилчдын кемп 150,000 төг*12 сар= 1,800,000 (нэг сая найман зуун мянган төгрөг)

Тав: Бусад нөхцөл

5.1 Хог хаягдал гаргасны төлбөр өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.

5.2 Гэрээгээр 2025 оны төлбөр тооцогдоно. 2025 оны 12 сарын 02-ны өдрөөр гэрээний хугацаа дуусгавар болно.

Гэрээ байгуулсан:

“Бласт” ХХК-ийг төлөөлж: Мандах сумын Засаг даргын Тамгын газрыг төлөөлж:
Ерөнхий нягтлан бодогч /Б.Шижирболд/ Байгаль орчны мэргэжилтэн
Хуулийн зөвлөх /Д.Содномжамц/ Утас: 88788434
/Д.Содномжамц/ IX.Эрдэмтөгс/
Мандах салбарын дарга /Х.Мягмарсүх/ IX.Мягмарсүх/
ХАЯГ: УБ хот, СБД 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-13, Ланд марк оффис, 3-р давхар
УТАС: (976-11) 330116
Цахим хаяг: info@blastcompany.mn

ДОРНОГОВЬ АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР
Орон нутгийн амын III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Утас: (976) 7052 2663, факс: (02-522) 4-27-26
Цахим шуудан: Dgaboajsgedo.mne.gov.mn
Цахим хаяг: www.do.mne.gov.mn
2025. 10. 01 № 518
танай _____ -ны № _____ -т

“БЛАСТ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ А.ТЭМҮҮЛИН ТАНАА

Танай 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 02/1004 тоот албан бичгээр ирүүлсэн 2025 оны Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө, Хайгуулын ажлын төлөвлөгөөг үндэслэн 2025 оны ус ашиглуулах дүгнэлтийг гарган хавсралтаар хүргүүлээ.

Хавсралтхуудастай.

Хувийг: Аймгийн Татварын хэлтэс, Мандах сумын Засаг даргын тамгын газарт

ДАРГА /Х.Мягмарсүх/ НОТГОНБЯАР

4425030598

ДОРНОГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР
2025 ОНЫ УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

- 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр Дугаар 63 Сайншанд хот
- 1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, хаяг, утас факс, улсын бүртгэлийн дугаар: “Бласт” ХХК, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-13, Ландмарк оффис, 3 давхарт, утас: 976-330117, 88803643, Улсын бүртгэлийн дугаар 9011125047, регистрийн дугаар 2688336
 - 2. Төслийн нэр, байршил: Мандах сумын Алхан тээг багийн нутагт орших “Тэсрэх бодисын хольцын үйлдвэр, агуулахын цогцолбор” төсөл
 - 3. Төсөл хэрэгжүүлэгч: “Бласт” ХХК
 - 4. Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн координат /X,Y/: 864

	X	Y	Урт
1.	287547.77	4866157.93	123.27
2.	287669.80	4866178.02	161.44
3.	287897.45	4866019.25	124.38
4.	287574.56	4865998.84	161.58
 - 5. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл зориулалт: Мандах сумын нутагт орших 864 тоот тусгай зөвшөөрөлтэй “Тэсрэх бодисын хольцын үйлдвэр, агуулахын цогцолбор” төсөл
 - 6. Үйлдвэрийн техник, технологи /ажиллах горим, хүчин чадал/: 2025 оны 01-р сарын 01-ээс 12-р сарын 31-ийг хүртэл ажиллана. Бүтээн байгуулалтын ажилд 89 хүний бүрэлдэхүүнтэй 1 ээлжээр нийт 350 хоног ажиллана. /2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө/
 - 7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ: Тус үйлдвэр агуулахыг цогцолбор нь нийт 10,44 га талбайг хамарч үйлдвэрийн байр, уурын зуух, тэсрэх материалын агуулах, оффис, авто гараж, усан сан, шатахуун түгээх станц, харуулын байр, цахилгааны дэд станц бүхий дэд бүтцийн байгууламжуудийг хийхээр төлөвлөсөн.
 - 8. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ /шоо метрээр/: Усны эх үүсвэр нь Галба-Өөш-Долоодын говийн сав газарт хамаарна. 2024 онд “Од шандас” ХХК-иар 3 худаг гаргуулсан. 0,13-1,2 л/сек ундратай. Хүн амын унд ахуй, технологийн хэрэглээ, ногоон байгууламжид ус ашиглана.
 - 9. Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, барилга, байгууламжийн хэмжээ хийц/: худаг 1. 108°19'41.54" E 43°54'51.29 N, 2. 108°19'37.85" E 43°54'59.80 N, 3. 108°19'53.97" E 43°54'34.79 N координаттай 0,13-1.2л/сек ундратай.
 - 10. Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур /насосны хүчин чадал, марк/: Эзэмшлийн 3 худагт тоолуур суурилуулан ашигладаг.

“Бласт” ХХК-ийн Мандах салбарын 2025 оны байгаль орчны
Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан

11. Дамжуулах байгууламж /шугам сүлжээний урт, диаметр/:

12. Хаягдал бохир усны хэмжээ, цэвэрлэгээний арга, түвшин:

13. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл:
Байгаль орчинд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 2024 онд “Төгрөг баян хангай” ХХК-иар хийлгүүлсэн.

14. Онцгой нөхцөл:

15. Холбогдох хууль, дүрэм, журам, норм, стандарт, баримт бичгийн дагуу усны зарцуулалтыг тооцох Байгаль орчны сайдын 2015 оны А/301 дугаар тушаалаар баталсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулах усны түр норм”-ын дагуу тооцоход


89 хүн x 20л/хон x 350 хон=623,0м³/жил – нийт ажиллах нийт хугацаанд-унд ахуйн усны хэрэглээ
1828,4м³ –технологийн хэрэглээ /Усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлт/
38700,0м² x 2л/м² x 1удаа/хон x 350 хон =27090,0м³ зам талбайн тоосжилт дарахад ашиглах ус
100ш x 40л x 84 удаа= 336,0м³ – ногоон байгууламжийн усалгаа
Нийт ашиглах усны хэмжээ: 623,0м³+1828,4 м³ +27090,0м³ +336,0м³ =29877,4м³

16. Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу онгодуулах усны нөөцийн төлбөрийн хэмжээ:
Технологийн хэрэглээ 1828,4м³, Замын талбайн тоосжилт дарахад ашиглах 27090,0м³, ногоон байгууламжийн усалгаанд ашиглах 336,0м³, ашиг олох зориулалтаар ашиглах 623,0м³ газрын доорх усны төлбөрийн хэмжээг “Усны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор Галба-Өөш-Долоодын говийн сав газарт тогтоосон газрын доорхи усны экологи эдийн засгийн суурь үнэлгээ, Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолоор тогтоосон ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын 1-р хавсралтын 3.9-д заасан усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээг үндэслэн тогтоож, хуулийн 23.6.5-д зааснаар ашигласан усны төлбөрийг аймгийн Төрийн сан 060000-944 дансанд төвлөрүүлж хувийг ирүүлэх
Монгол улсын Засгийн газрын 2013 оны 326, 327 дугаар тогтоолыг үндэслэн ус ашигласны төлбөрийг тооцвол:
1м³ усны нөөц ашигласны төлбөр: 3996төг/м³ x 0.20 x 0.25=199.8төг/м³ байна.
- Галба-Өөш-Долоодын говийн сав газарт-т газрын доорх ус ашигласан нөхцөлд тооцох экологи-эдийн засгийн суурь үнэлгээ 3996 төг/м³ байна.
-20 хувь -Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 7-д заасан хувь хэмжээ.
- 0.25- ашиглах усны ашиглалтын зориулалтын итгэлцүүр
- 27090,0м³ жилд – зам талбайн тоосжилт дарах
27090,0 м³ x 199,8= 5412582,0 төг /таван сая дөрвөн зуун арван хоёр мянган таван зуун наян хоёр төгрөг/
1м³ усны нөөц ашигласны төлбөр: 3996төг/м³ x 10 x 0.25=99.9 төг/м³ байна.
- 3996төг/м³: “Галба-Өөш Долоодын говийн сав газар”-т газрын доорх ус ашигласан нөхцөлд тооцох экологи, эдийн засгийн суурь үнэлгээ
- 10 хувь -Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 9-д заасан хувь хэмжээ.

- 0.18- Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолын дагуу Ногоон байгууламжийн зориулалтаар газрын доорхи усыг ашиглахад тооцох ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр
336,0м³ x 72,0= 24192,0 төг /хорин дөрвөн мянга нэг зуун ерэн хоёр төгрөг/
1м³ усны нөөц ашигласны төлбөр: 3996төг/м³ x 0.15 x 0.16=95,9 төг/м³ байна.
- 3996төг/м³: “Галба-Өөш Долоодын говийн сав газар”-т газрын доорх ус ашигласан нөхцөлд тооцох экологи, эдийн засгийн суурь үнэлгээ
- 15хувь -Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 4-д заасан хувь хэмжээ.
- 0.16- Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолын дагуу ашиг олох зориулалтаар ашиглах газрын доорхи усыг ашиглахад тооцох ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр
2451,4м³жил x 95,9 төг/м³=235089,2 төг /хоёр зуун гучин таван мянга наян есөн төгрөг хоёр мөнбөр/
Нийт: 5412582,0 төг +24192,0 төг + 235089,2 төг = 5671863,2 төг /таван сая зургаан зуун далан нэгэн мянга найман зуун жаран гурван төгрөг хоёр мөнбөр /

17. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмхэн, эргүүлж ашиглах даалгавар:

18. Төвхөн шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөмж:
- Ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн Мандах сумын Засаг даргын захирамжаар ус ашиглах зөвшөөрөл авч гэрээ байгуулах /Усны тухай/ хуулийн 28.6-р зүйл/
- Усны шийжлэгээг хийлгэж дүнг ирүүлэх
- Хаягдал усны цэг тогтоологдох, дүгнэлт гаргуулан зөвшөөрөл авч гэрээ байгуулах
- Тоолууржуулан баталгаажсан тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг тооцож байх /Усны тухай хуулийн 30.1.4-д усны эх үүсвэрийг /БОНХС-ын 2013 оны А-156 тоот тушаалаар батлагдсан “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”/
- “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэм”-ийг мөрдөн ажиллах /Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 хамтарсан тушаал/
- “Аж ахуйн нэгжийн экологийн паспорт” хөтлөх /Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйл, Стандартчилал хэмжээний хэлтсээс авах/
- Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг 50 хүртэл хувирч өсгөн тооцож төлөхөөр заасныг анхаарч ажиллах /Усны тухай хуулийн 31.2-р зүйл/
- Ус ашиглах зөвшөөрлийн хураамжийг Мандах сумын Төрийн сан Банкны дансанд тушааж хуульбар хувийг ирүүлэх /Монгол Улсын “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуулийн 21.1, 20-р зүйл, Дорноговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2011 оны 51-р тогтоол/
- Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс болох 50 000 төгрөгийг Байгаль орчны газрын Төрийн сан банкны 100 060013001 дансанд тушаах /Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2018 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А-376 тоот тушаал/
Зөвлөмжид заасан ажлын тайлан, Ус ашиглалтын мэдээ тайланг 11-р сарын 05-нд багтаан аймгийн Байгаль орчны газарт ирүүлэх

БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН:  Ш. АМГАЛАНСАЙХАН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГА:  Н. ОТГОНБАЯР

НЭХЭМЖЛЭХ №

Нэхэмжлэгч:
Байгууллагын нэр: Байгаль орчны газар
Дансны нэр: До. Байгаль орчны газар
Хаяг Орон нутгийн өмчийн 3 байр
Утас, факс 70522663
Э-шуудан
Регистрийн дугаар: 9028668
Банкны дансны дугаар: MN510090100060013001
Банкны нэр: Төрийн сан банк

Төлөгч:
Байгууллагын нэр “Бласт” ХХК
Хаяг: Мунзаг сум.
Гэрээний № _____

Нэхэмжилсэн огноо:
Төлбөр хийх хугацаа:

№	Гүйлгээний утга	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Дүгнэлт гаргуулсны үйлчилгээний хураамж	1	50,000.00	50,000.00
				-
				50,000.00

Дүн
НӨАТ
Нийт дүн

Мөнгөний дүн : Тавин мянган төгрөг

(Тамга) Дарга (үсгээр)
Нягтлан бодогч:  Н.Отгонбаяр/
Б.Энхзул/

ТӨРИЙН БАНК
 ЭРСЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

МӨНГӨН ШИЛЖҮҮЛЭГ / MONEY TRANSFER

Он/YY Cap/MM Өдөр/DD
 2025.10.13

Хүлээн авагчийн /Beneficiary's:

Банкны нэр / Bank name:	Дансны № / Account №:	Нэр (байгууллага эсвэл иргэн) / Name (organization or individual):
ТӨРИЙН САН	MN510090100060013001	До.Байгаль орчны газар
Мөнгөн дүн тоогоор/ Amount:	Мөнгөн дүн үсгээр/ Amount in words:	Валют/ Currency:
50,000.00	Тавин мянган төгрөг	MNT
Гүйлгээний утга, бусад тэмдэглэл/ Details of payment:		Нууц код/ Code:
БЛАСТ ХХК		

Шилжүүлэгчийн / Sender's

Банкны нэр/ Bank name:	Дансны №/ Account №:	Нэр (байгууллага эсвэл иргэн)/ Name (organization or individual):
ТӨРИЙН БАНК	510090100060013001	ТАМИРМОНХ БЦ79120171-99548722
Мөнгөн дүн тоогоор/ Amount:	Валют/ Currency:	Гүйлгээний төрөл/ Transaction type
50000 50,000.00	MNT	Банк хоорондын бэлэн гүйдлээ-13600506
Харилцагчийн тэмдэглэл/ Customer note:		

Тамга/ Stamp: _____ Баталгаат гарын үсэг/ Authorized signature:
 1. _____ 2. _____ 3. _____

Банкны тэмдэглэл/ For bank use only:

Теллер №	Журнал №	Огноо	Гүйлгээний хураамж	Шилжүүлэгчийн биеийн байцаалтын төрөл №	Теллер гарын үсэг
10756/2800	641740R74946	2025.10.13 14:26	500.00		

3.2.2 Холбогдох байгууллагаас хаягдал усны дүгнэлт, зөвшөөрөл авч ажиллах

BLAST COMPANY
“БЛАСТ” ХХК
 14253 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
 1 дүгээр хороо, Мөнхсайн өргөн чөлөө-13,
 Ландмарк оффис, III давхарг
 Утас: 32-89-85, Факс: (076-11) 33-01-17
 E-mail: info@blastcompany.mn
 Website: www.blastcompany.mn

2025.09.17 № 02/997
 танай _____ -ны № _____ -т

Хаягдал усны дүгнэлт гаргуулах тухай

Манай компани нь 2001 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд тэрэх бодисын үйлдвэрлэл, тээвэрлэл, тээвэрлэл ажил үйлчилгээ, тэрэх материалын импорт худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Тус компани нь Дорноговь аймгийн Мандах сумын нутагт байрлах “Тэрэх бодисын хольцын үйлдвэр, агуулахын цогцолбор батлагдсан ТЭЗҮ-ийн дагуу хэрэгжүүлэхээр бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлээд байна.

